



ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 7.5.7 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32¹ дүгээр зүйлийн 32¹.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Цахим үндэстэн" бодлогын баримтлах чиглэлийн хүрээнд цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалтын агуулга, хөтөлбөрийг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор боловсруулж, танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Одбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.БАТБААТАР

153301000462



Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын
газрын даргын 2023 оны 27 дугаар сарын 21 ны өдрийн
А/4.3. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Одбаяр

Систем нэгтгэл, Сургалт хөгжлийн газрын дарга

Гишүүд:

М.Тэлмүүнсайхан

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын
хэвлэлийн төлөөлөгч; /зөвшилцсөнөөр/

Д.Сэлэнгэ

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим
ур чадвар, салбарын хүний нөөцийн бодлого
хариуцсан мэргэжилтэн; /зөвшилцсөнөөр/

Х.Тэмүжин

Захиргаа удирдлагын газрын Хоёр талт хамтын
ажиллагаа хариуцсан мэргэжилтэн;

Ж.Хүрэлчимэг

Сургалт хөгжлийн хэлтсийн Сургалт хариуцсан
мэргэжилтэн;

А.Солонго

Чанар хяналтын мэргэжилтэн;

В.Лут-Очир

“И-Монгол академи” УТҮГ-ын Цахим ур чадварын
газрын дарга; /зөвшилцсөнөөр/

С.Болортулга

“И-Монгол академи” УТҮГ-ын Цахим ур чадвар
олгох сургалт хариуцсан мэргэжилтэн;
/зөвшилцсөнөөр/

Э.Пүрэвдаваа

“И-Монгол академи” УТҮГ-ын Мэдээлэл
технологийн мэргэжилтэн; /зөвшилцсөнөөр/

Б.Доржжагдаг

“И-Монгол академи” УТҮГ-ын Сургагч багш;
/зөвшилцсөнөөр/

Ажлын хэсгийн нарийн
бичгийн дарга:

Б.Отгонбаяр

Сургалт хөгжлийн хэлтсийн дарга.



Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын
газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн
А/43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5 дугаар зорилтын 7.5.7 дахь заалтад “Төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацыг ашиглах чадавхыг дээшлүүлнэ.” гэж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.18 дахь заалтад Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт “нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаа, нээлттэй өгөгдлийн талаар олон нийтэд сурталчлах, иргэний харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ, сургалт зохион байгуулах.” хамаарна гэж тус тус заасан байна.

Хоёр. Зорилго

Төрийн албан хаагч, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулахад оршино.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

“Цахим үндэстэн” бодлогын баримтлах чиглэлийн хүрээнд төрийн албан хаагч, иргэдэд зориулсан сургалтын агуулга, хөтөлбөрийг 2023 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор боловсруулж, танилцуулах.

Хамтран оролцогч байгууллагууд:

- Цахим хөгжил, харилцаа холбооны яам;
- Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар;
- “И-Монгол академи” УТҮГ;

---oOo---

